

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/006/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2026

2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5.1. Төлбөрийн акт.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Орон нутгийн өмчийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕГ	Татварын Ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ТАТВАРЫН
ГАЗРЫН ДАРГА С.РЭНЦЭНДАГВА
ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026. 02.10 № 2/03

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 70205 (Татвар хураалт, орлого бүрдүүлэлт) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 2,341,216.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, тус санхүүжилтээс 99.9 хувь буюу 2,339,132.9 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, зардлын хэмнэлтийн 2,083.9 мянган төгрөгийг оны улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Баянхонгор аймгийн Татварын газар нь 2025 онд “Зөвлөн туслагч татварын алба” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 5 зорилтын дагуу 23 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, оны эцэст холбогдох байгууллагуудад тайлагнасан боловч уг тайланг дээд шатны байгууллагаас үнэлээгүй байна. Харин байгууллагын даргын 2025 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг аймгийн Засаг дарга 96.9 хувиар үнэлжээ.

Бусад асуудал

Баянхонгор аймгийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 2025 онд аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/279 дүгээр захирамжаар “Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, хяналтын ажлыг эрчимжүүлэх”, 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/559 дугаар захирамжаар “Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллого зохион байгуулах” арга хэмжээнд 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон, эдгээр ажлуудыг хэрэгжүүлсний үр дүнд 2025 оны эхэнд байсан бүртгэлтэй татвар төлөгчийн тоо 9.3 хувиар өссөн, үл хөдлөх эд хөрөнгийн татварын гүйцэтгэл өмнөх оноос 4 дахин өсөж, 2,613,500.4 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	81,069,595.62	70,742,136.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,590,000.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,590,000.00	0.00
3121	Төгрөг	3,590,000.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	3,590,000.00	0.00
33	АВЛАГА	652,229.10	6,092,974.12
335	Бусад авлага	652,229.10	6,092,974.12
3351	Байгууллагаас авах авлага	652,229.10	6,092,974.12
35	БАРАА МАТЕРИАЛ	76,827,366.52	64,649,162.38
354	Хангамжийн материал	76,827,366.52	64,649,162.38
35410	Бичиг хэргийн материал	7,054,561.00	3,810,061.00
35420	Аж ахуйн материал	16,059,566.00	13,419,566.00
35430	Сэлбэг хэрэгсэл	418,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	534.14	0.00
35450	Барилгын засварын материал	630,500.00	865,000.00
35470	Бусад хангамжийн материал	52,664,205.38	46,554,535.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,125,013,391.78	2,109,695,074.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,125,013,391.78	2,109,695,074.02
392	Биет хөрөнгө	2,079,803,391.78	2,064,485,074.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,043,583,200.00	2,043,583,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,121,656.35	-122,158,063.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,990,000.00	69,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-105,697,859.43	-20,811,467.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	319,446,682.88	322,906,985.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-225,053,198.60	-261,168,933.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,289,000.00	61,807,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,632,776.72	-29,663,647.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,780,000.00	3,780,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,780,000.00	-3,780,000.00
393	Биет бус хөрөнгө	45,210,000.00	45,210,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	45,210,000.00	45,210,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,206,082,987.40	2,180,437,210.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,272,167.84
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,272,167.84
413	Өглөг	0.00	1,272,167.84
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	546,310.00
4136	Бусад өглөг	0.00	725,857.84
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	700,000.00
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	0.00	25,857.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,206,082,987.40	2,179,165,042.68
51	Засгийн газрын хувь оролцоо	2,206,082,987.40	2,179,165,042.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	268,961,050.75	268,961,050.75
51101	Өмч: - төрийн	268,961,050.75	268,961,050.75
512	Хуримтлагдсан үр дүн	1,801,671,200.08	1,774,753,255.36
51210	Өмнөх үеийн үр дүн	1,898,967,628.52	1,801,671,200.08
51220	Тайлант үеийн үр дүн	-97,296,428.44	-26,917,944.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,450,736.57	135,450,736.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,206,082,987.40	2,180,437,210.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,490,036,787.50	2,478,898,194.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,479,000.00	85,667,632.43
120	Нийтлэг татварын бус орлого	15,479,000.00	85,667,632.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,479,000.00	23,974,862.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,444,000.00	23,974,862.43
120009	Бусад орлого	0.00	61,692,770.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,474,557,787.50	2,393,230,562.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,432,263,300.00	2,341,216,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,432,263,300.00	2,341,216,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,294,487.50	52,013,762.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,294,487.50	52,013,762.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,587,333,215.94	2,505,816,139.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,587,333,215.94	2,505,816,139.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,411,596,379.16	2,447,871,317.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,801,369,076.55	1,828,413,431.13
210101	Үндсэн цалин	756,495,151.67	820,578,073.47
210102	Нэмэгдэл	507,134,443.83	630,558,965.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	91,861,975.22	82,524,589.33
210104	Урамшуулал	445,877,505.83	294,751,803.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	223,133,198.65	229,474,161.03
210201	Тэтгэврийн даатгал	155,481,702.65	160,214,949.47
210202	Тэтгэмжийн даатгал	16,961,100.00	17,438,055.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,480,600.00	7,620,456.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,480,600.00	7,114,934.00
210205	Эрүүл мэндийн даатгал	33,729,196.00	37,085,765.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,182,572.91	131,655,228.04
210301	Гэрэл, цахилгаан	6,059,440.91	7,441,995.24
210302	Түлш, халаалт	104,428,192.00	115,260,992.80
210303	Цэвэр, бохир ус	7,694,940.00	8,952,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,032,656.39	23,064,378.14
210401	Бичиг хэрэг	4,911,607.91	6,330,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,835,901.00	8,693,519.14
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,610,672.90	2,404,359.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,474,474.58	4,436,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,073,567.51	1,955,000.00
210604	Урсгал засвар	10,073,567.51	1,955,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,262,000.00	6,650,000.00
210702	Дотоод албан томилолт	18,262,000.00	6,650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,805,078.00	112,666,768.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,975,369.00	111,829,278.67
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,280.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,024.00	242,500.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	377,910.00	380,710.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,738,229.15	113,992,350.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,607,189.07	11,833,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,625,000.00	1,216,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,506,040.08	100,943,170.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175,736,836.78	57,944,822.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	173,275,700.00	54,296,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	170,775,700.00	53,316,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	980,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,461,136.78	3,648,822.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,461,136.78	3,648,822.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-97,296,428.44	-26,917,944.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-97,296,428.44	-26,917,944.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,474,592,787.50	2,393,273,332.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	42,770.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	42,770.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	0.00
120009	Бусад орлого	0.00	42,770.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,474,557,787.50	2,393,230,562.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,432,263,300.00	2,341,216,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,432,263,300.00	2,341,216,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,294,487.50	52,013,762.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,294,487.50	52,013,762.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,484,032,787.50	2,396,863,332.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,484,032,787.50	2,396,863,332.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,308,155,950.72	2,337,108,510.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,801,722,073.91	1,841,074,108.01
210101	Үндсэн цалин	756,495,151.67	876,523,266.52
210102	Нэмэгдэл	507,487,441.13	576,615,144.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	91,861,975.28	82,007,309.33
210104	Урамшуулал	445,877,505.83	305,928,387.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	224,021,689.00	221,252,650.00
210201	Тэтгэврийн даатгал	156,370,193.00	150,520,650.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,961,100.00	17,681,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,480,600.00	8,840,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,480,600.00	8,838,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	33,729,196.00	35,372,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,181,572.91	131,543,399.04
210301	Гэрэл, цахилгаан	6,058,440.91	7,441,996.04

210302	Түлш, халаалт	104,428,192.00	115,260,992.00
210303	Цэвэр, бохир ус	7,694,940.00	8,840,411.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,895,473.90	15,296,013.00
210401	Бичиг хэрэг	4,764,300.00	2,654,700.00
210402	Тээвэр, шатахуун	7,781,901.00	5,542,135.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,714,272.90	2,000,378.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,435,000.00	3,798,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,834,100.00	2,505,000.00
210604	Урсгал засвар	10,834,100.00	2,505,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,262,000.00	6,650,000.00
210702	Дотоод албан томилолт	18,262,000.00	6,650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,239,041.00	116,771,340.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,409,332.00	115,933,850.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,280.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,024.00	242,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	377,910.00	380,710.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	2,016,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	1,216,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175,876,836.78	59,754,822.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	173,415,700.00	54,884,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	170,775,700.00	53,316,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.00	1,568,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,461,136.78	4,870,822.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,461,136.78	4,870,822.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-9,440,000.00	-3,590,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-9,440,000.00	-3,590,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,030,000.00	3,590,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,590,000.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	1,898,967,628.52	2,303,379,415.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	1,898,967,628.52	2,303,379,415.84
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-97,296,428.44	-97,296,428.44
C08	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	537,922,101.50	270,901,473.14	3,603,342,400.16	4,412,165,974.80
D01	2025 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	537,922,101.50	270,901,473.14	3,603,342,400.16	4,412,165,974.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	537,922,101.50	270,901,473.14	3,603,342,400.16	4,412,165,974.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-26,917,944.72	-26,917,944.72
D09	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	1,774,753,255.36	2,179,165,042.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,391,098,600.00	2,339,132,897.75	51,965,702.25	97.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,391,098,600.00	2,339,132,897.75	51,965,702.25	97.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,337,782,600.00	2,285,816,897.75	51,965,702.25	97.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,854,957,400.00	1,814,891,195.71	40,066,204.29	97.84
210101	Үндсэн цалин	968,599,800.00	878,523,266.52	90,076,533.48	90.70
210102	Нэмэгдэл	525,842,000.00	548,432,232.45	22,590,232.45	104.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,335,000.00	82,007,309.33	2,327,690.67	97.24
210104	Урамшуулал	276,180,600.00	305,928,387.41	-29,747,787.41	110.77

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,543,400.00	131,543,399.04	0.96	100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,415,000.00	7,441,996.04	-26,996.04	100.36
210302	Түлш, халаалт	115,261,100.00	115,260,992.00	108.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	8,867,300.00	8,840,411.00	26,889.00	99.70
2104	Хангамж, бараа материалын зардал	19,315,900.00	15,296,013.00	4,019,887.00	79.19
210401	Бичиг хэрэг	5,142,400.00	2,654,700.00	2,487,700.00	51.62
210402	Тээвэр, шатахуун	5,790,000.00	5,542,135.00	247,865.00	95.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,997,400.00	2,000,378.00	997,022.00	66.74
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,197,300.00	1,300,000.00	-102,700.00	108.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,188,800.00	3,798,800.00	390,000.00	90.69
2107	Томилолт, зочны зардал	10,799,600.00	4,650,000.00	6,149,600.00	43.06
210702	Дотоод албан томилолт	10,799,600.00	4,650,000.00	6,149,600.00	43.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,423,500.00	94,693,490.00	730,010.00	99.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,207,300.00	93,856,000.00	351,300.00	99.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	0.00	300,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	178,200.00	170,280.00	7,920.00	95.56
210807	Газрын төлбөр	451,500.00	380,710.00	70,790.00	84.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,216,000.00	1,216,000.00	1,000,000.00	54.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	0.00	1,000,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,391,098,600.00	2,339,132,897.75	51,965,702.25	97.83
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,391,098,600.00	2,339,132,897.75	51,965,702.25	97.83
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,391,098,600.00	2,339,132,897.75	51,965,702.25	97.83
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	43	43	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39	39	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,030,000.00	3,590,000.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,734,487.50	55,646,532.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,734,487.50	55,646,532.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,734,487.50	51,291,612.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,607,885.50	26,182,912.30
210102	Нэмэгдэл	35,607,885.50	26,182,912.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,086,602.00	230,850.00
210201	Тэтгэврийн даатгал	3,086,602.00	230,850.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,040,000.00	22,077,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,040,000.00	22,077,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,568,000.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,568,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,568,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	2,786,920.20
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,786,920.20
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,294,487.50	52,056,532.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,294,487.50	52,056,532.50
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,294,487.50	52,013,762.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	42,770.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-9,440,000.00	-3,590,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,030,000.00	3,590,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,590,000.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Татварын газар "Татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулах" эрхэм зорилготой тус байгууллага нь төрийн захиргааны 37, төрийн үйлчилгээний 6, нийт 43 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга С.Рэнцэндагва, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Бат-Орших нар зурж, нярваар бичиг хэргийн ажилтан Ж.Буяннэмэх ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 1,2,3 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 1,2 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр 1,2 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн баталсныг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Татварын Ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/156 дугаар тушаалаар батлагдсан Монголын татварын албаны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаанд мөрддөг, тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан маягын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,645.8 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,590.00	0.00	(3,590.00)
Авлага	652.23	6,092.97	5,440.75
Бараа материал	76,827.37	64,649.16	(12,178.20)
Үндсэн хөрөнгө	2,125,013.39	2,109,695.07	(15,318.32)
Хуримтлагдсан элэгдэл	(455,285.49)	(437,582.11)	17,703.38
Нийт хөрөнгө	1,750,797.50	1,742,855.10	(7,942.40)
Өр төлбөр	0.00	1,272.17	1,272.17
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,206,082.99	2,179,165.04	(26,917.94)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,206,082.99	2,180,437.21	(25,645.78)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын газрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Татварын газрын 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Өмнөх оны эцэст 652.2 мянган төгрөгийн авлага нь нийгмийн даатгалын даатгалын авлагатай байсан, тайлант онд өмнөх оноос авлага 5,440.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын нягтлан бодогч хог хаягдлын хураамжийн 100.0 мянга, хувь хүний орлогын албан татварыг 4,770.1 мянган төгрөгийг давхардуулан шилжүүлсэн, ахмадын сангийн үлдэгдэл 1,222.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, санхүүгийн тайланд авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 12,178.2 мянган төгрөгөөр буурч 64,649.2 мянган төгрөг болсон нь газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/38 дугаар тушаалаар 11,072.2 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 15,318.3 мянган төгрөгөөр буурч, оны эцэст 2,109,695.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон нь тайлант онд ТӨБЗГ-ын даргын 2025 оны А-1/2135 дугаартай албан бичгээр 23,974.9 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, ТӨБЗГ-ын 544 дүгээр “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” тогтоолын дагуу 98,485.3 мянган төгрөгийн балансын өртгийг хуримтлагдсан элэгдлээрээ элэгдүүлж дууссан хөрөнгийг 61,650.0 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэлд тусгасан, ТӨБЗГ-ын 2025 оны 692 дүгээр тогтоолын дагуу 20,161.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 26,917.9 мянган төгрөгөөр хасагдан, 2,180,437.2 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төслийг 2,595,706.2 мянган төгрөгөөр баталж, Татварын Ерөнхий газарт хүргүүлсэн байна.

Татварын Ерөнхий газар хүргүүлсэн төсвийн төслийг 168,468.4 мянган төгрөгөөр бууруулан 2,427,237.8 мянган төгрөгөөр баталсан байгаа нь цалин, хангамжийн материалын зардал, томилолтын зардал, ахмадын санд олгох санхүүжилтийг бууруулсан нь нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Оны эцэст баталсан төсвийг 36,139.2 мянган төгрөгөөр бууруулан 2,391,098.6 мянган төгрөгөөр баталж, тайлант онд баталсан санхүүжилтийн 97.9 хувь буюу 2,341,216.8 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авчээ.

Дээрх санхүүжилтээс төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70205 (Татвар хураалт, орлого бүрдүүлэлт) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 99.9 хувь буюу 2,339,132.9 мянган төгрөгийг үйл

ажиллагаанд зарцуулж, зардлын хэмнэлтийн 2,083.9 мянган төгрөгийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70205	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,243,575.30	2,191,959.90	51,615.40	97.70
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	350.00	0.00	350.00	0
80205	Харуул хамгаалалтын зардал	43,201.30	43,201.30	0.00	100
80220	Холбооны суваг ашигласны хөлс	50,656.00	50,656.00	0.00	100
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	53,316.00	53,316.00	0.00	100
	ДҮН	2,391,098.60	2,339,133.20	51,965.40	97.83

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын газрын төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ерөнхий чиглэлийн судалгааны талаар

ҮАГ-аас нэгдсэн журмаар авч байгаа ерөнхий чиглэлийн 8 судалгаанаас хамааралтай дараах 4 судалгааг гаргаж ажлын баримтад хавсаргав.

Орон тоо, бүтцийн талаар: ТЕГ-аас 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Хэлтсийн орон тоог шинэчлэн батлах тухай” А/04 дүгээр тушаалаар Баянхонгор аймгийн Татварын газрын бүтэц орон тоог 43-аар баталсны дагуу орон тоог мөрдөж ажилласан байна. Тайлант онд цалин хөлс нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 2,035,912.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. 2026 оны төсвийн хуваарьт орон тоог 39-өөр баталж, гүйцэтгэх албан тушаалтнаас 4 орон тоог хасахаар ирсэн ч орон тоог албан тушаалаар баталсан шийдвэр ТЕГ-аас ирээгүй байна.

- Хоолны хөнгөлөлтийн талаар: ТЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/212 албан бичгийг үндэслэн байгууллагын албан хаагчдад 1 өдөрт 8.4 мянган төгрөгийн хоолны зардал олгож, тайлант онд хоолны зардалд 84,335.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 82,552.8 мянган төгрөгийг олгосон байна.
- Мэдээллийн технологийн зардлын тухайд: Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийг "Интерактив BI" ХХК-ийн санхүүгийн “EMERALD” программыг ашиглан бэлтгэсэн, тус программ нь ТЕГ-т бүртгэлтэй программ тул жилийн үйлчилгээний төлбөрт төлбөр төлдөггүй байна.
- Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд зарцуулсан зардлын судалгаа: Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн А/26 тоот тушаалаар тус газрын нийт албан хаагчдын 2025 оны нэгдсэн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж 1,036.0 мянган төгрөг зарцуулах шийдвэр гарсны дагуу зардлыг гаргаж, А/18 тоот тушаалаар стандартын сургалтын төлбөрт 180.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайланд оны эхэнд Төрийн сан дахь ахмадын сангийн 100030011501 тоот данс 3,590.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан, тайланд онд ахмадуудын баярын үйл ажиллагааны зардалд нийт 2,368.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст харилцах дансны үлдэгдэл 1,222.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, санхүүгийн тайланд авлагаар тусгажээ.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030011401 дансанд орон нутгийн нэмэгдэлд орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн 26,413.7 мянга, хяналт шинжилгээ үнэлгээний дүнгийн шагналын 5,000.0 мянга, жендерийн мэдрэмжтэй байгууллагын шагналын 600.0 мянга, Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 20,000.0 мянга, хүчингүй болсон албан бланкны 42.8 мянга, нийт 52,056.5 мянган төгрөгийн орлого орсон байна.

Дээрх санхүүжилтээс холбогдох зардлуудыг байгууллагын даргын тушаалаар зарцуулж, зардлын хэмнэлтийн 1,564.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баянхонгор аймгийн Татварын газар нь 2025 онд “Зөвлөн туслагч татварын алба” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 5 зорилтын дагуу 23 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, оны эцэст холбогдох байгууллагуудад тайлагнасан боловч уг тайланг дээд шатны байгууллагаас үнэлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай 346 дугаар албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ирүүлж, 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон аудитад шаардлагатай баримт, материалыг 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн 2,391,098.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,910.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 15,542.1 мянган төгрөгөөр тогтоосон ба гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасны дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг аудитаар хянахад хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчилд 77,423.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, шалгагдагч байгууллага шийдвэрийн хэрэгжилтийг FAS системд мэдээлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	85,105,300.0	1	85,105,300.0	100.00
Төлбөрийн акт	2	687,661.0	2	687,661.0	100.00
Албан шаардлага	2	1,277,400.0	2	1,277,400.0	100.00
Нийт дүн	5	87,070,361.0	5	87,070,361.0	

Эх сурвалж: Татварын газрын 2025.05.26-ны өдрийн 120 дугаар албан бичиг

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Татварын газрын ажилтнуудад урамшуулал цалин давхардасан эсэхийг нягтлаж үзэхэд Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, 51.1.4, 51.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2 дахь заалтыг үндэслэн төсвийн захирагч албан хаагчдад улирлын урамшууллыг газрын даргын тушаалаар, Ерөнхий хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, 80.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 33 дугаар тушаалаар баталсан "Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам"-ын дагуу албан хаагчдын үндсэн цалингийн 50 хүртэл хувиар, татварын орлогын биелэлтийг харгалзан сар бүрийн урамшуулалыг Татварын ерөнхий газрын шийдвэрээр олгосон байна.

Иймд тус асуудлын орон нутгийн татварын байгууллагаас шалтгаалаагүй дээд шатны байгууллагаас нь шийдвэрлэн олгож байгаа тул системээр үзэж шийдвэрлэн, нэгдсэн журмаар Татварын Ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд анхаарч үзэх саналтай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй, 4,870.9 мянган төгрөгийн 1 зөрчил¹ илэрснийг материаллаг алдаагаар тооцож, төлбөрийн акт тогтоосон ба аудитаар илэрсэн дээрх зөрчил нь бидний урьдчилан тогтоосон материаллаг дүнгээс бага тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өглөө.

5.1. Төлбөрийн акт

1. Тайлант оны 10-11 саруудад албан хаагчдын цалингаас хувь хүний орлогын албан татварын суутгалыг 2025 оны 12 дугаар сард шилжүүлэхдээ 4,770.9 мянга, хог хаягдлын хураамжийг 100.0 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалт, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 3/1/АДС60238/БМА-2026/НА-СТА - ТМЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 10-11 саруудад албан хаагчдын цалингаас хувь хүний орлогын албан татварын суутгалыг 2025 оны 12 дугаар сард шилжүүлэхдээ 4,770,974 (Дөрвөн сая долоон зуун далан мянга есөн зуун далан дөрвөн) төгрөгөөр, хог хаягдлын хураамжийг 100,000 (Нэг зуун мянга) төгрөгөөр тус тус илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү шилжүүлсэн хувь хүний орлогын албан татварын 4,770,974 (Дөрвөн сая долоон зуун далан мянга есөн зуун далан дөрвөн) төгрөг, хог хаягдлын

хураамжийн 100,000 (Нэг зуун мянга) төгрөгийг Баянхонгор аймгийн Татварын газрын 2026 оны төсвөөс нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Бусад татвар хураамжийн 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2026 оны 05 дугаар сарын 04-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Татварын газрын дарга С.Рэнцэндагва, нягтлан бодогч Д.Бат-Орших нарт даалгав^{1,2}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно